

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Э.Болормаа, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, С.Зулпхар, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгээрэл, Ө.Шижир, Л.Энх-Амгалан.

Нэг.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын Бүсчилсэн хөгжлийн болон Ёс зүйн дэд хороодын бүрэлдэхүүнийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, Ц.Идэрбат, Н.Номтойбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Г.Уянгахишиг нарыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Б.Баярбаатар, Д.Энхтуяа, Ч.Лодойсамбуу, Ч.Номин, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Ө.Шижир нарыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 40 минут.*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Цагаанхүүгийн Идэрбат, Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Сандаг-Очир, Бадарчийн Хэрлэн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жудагийн Баярмаа, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Эрдэнэбилэгийн Одбаяр, Отгоны Саранчулуун, Доржхандын Энхтуяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Амгаланбаатарын Ганбаатар, Чинбатын Номин, Бөхчулууны Пүрэвдорж, Гончигдоржийн Уянгахишиг нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе. Дэд хорооны бүрэлдэхүүний Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны болон Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэнэ. Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны дэргэдэх Бүсчилсэн хөгжлийн болон Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Бүсчилсэн хөгжлийн дэд хороо Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Энхбатын Болормаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жадамбын Бат-Эрдэнэ, Цэндийн Сандаг-Очир. Ёс зүйн дэд хороо Баярмагнайн Баярбаатар, Аюушийн Ариунзаяа, Чинбатын Номин, Бадарчийн Хэрлэн, Отгоны Саранчулуун. Энэ чинь тийм байна шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг дахиж өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Бүрэлдэхүүнийг дахин танилцуулъя. Бүсчилсэн хөгжлийн дэд хороо Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Энхбатын Болормаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жадамбын Бат-Эрдэнэ, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэвэгдоржийн Туваан. 9 гишүүн.

Ёс зүйн дэд хороо Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Чинбатын Номин, Бадарчийн Хэрлэн, Отгоны Саранчулуун, Доржзовдын Энхтуяа, Оюунсайханы Алтангэрэл, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Өлзийхүүгийн Шижир гэсэн ийм бүрэлдэхүүнд танилцуулж байна.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Асуулт байгаа юм уу? Би сая асуусан шүү дээ, хэлсэн. Ганбаатар гишүүн асуулт тасаллаа. Ганбаатар гишүүний микрофон өгье.

А.Ганбаатар: Уучлаарай, баярлалаа. Энэ нөгөө 2 дэд хороонд чинь хүмүүс хуваагдчихаар дунд нь үлдсэн хүмүүс нь яах юм бэ? Тухайлбал Баярмаа, Ганбаатар гээд бид 2 ингээд хоцорч байна. Аль нэг хороонд нь харьяалагдахгүй. Тийм. Зүгээр л 2 хувааж болдоггүй юм уу?

Ц.Сандаг-Очир: Ганбаатар гишүүний асуултад Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль баталж, бүрэлдэхүүн шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор ерөнхий намын бүлгүүдийн саналуудаа тусгаад, тэгээд тэрийгээ нэгтгэж байгаад, Байнгын хороодоо бүрэлдэхүүнийг нь зоогоод, тэгээд тэндээсээ ерөнхийдөө гишүүдийнхээ ажилладаг зарчмынх нь дагуу урьд өмнө нь харьяалагдаж байсан Байнгын хороодоор нь дэд хороодоо юу яасан юм бүрэлдүүлчихсэн юм.

Тэгэхээр сая Эдийн засгийн байнгын хороон дээр санал гарч ирж байна лээ. Энэ бүрэлдэхүүнээрээ хэдүүлээ баталчихъя. Тэгээд намар орж ирээд, бүлгүүд хоорондоо ярьж байгаад ямар, ямар луу, дэд хороо руу хоорондоо шилжих бололцоотой юм, ямар санал гарч ирэх юм гэдгээ намар бүлэг, бүлэг дээрээ ярьж байгаад, нэгтгээд дахин хуралдаад, тэрийгээ баталчихвал яасан юм бэ гэсэн ийм санал гарсан байгаа. Тэгээд намар явчихсан нь дээр юм болов уу гэсэн. Одоо хэдүүлээ цаг хугацаа бага байгаа болохоор энийгээ батлаад шууд явчихвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Санал хураалтдаа бэлдээрэй гишүүд. Санал хураалт. Монгол Улсын Их Хурлын Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа, Цагаанхүүгийн Идэрбат, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг гэсэн нарын 9 гишүүнийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 88,9 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Доржзовдын Энхтуяа, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир нарын 9 гишүүнийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 88,9 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын Их Хурлын Бүсчилсэн хөгжлийн болон Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

Үдээс хойш Байнгын хороо дахиж хуралдаж, энэ дэд хороодын 2 даргыг сонгох асуудал байгаа. Байнгын хорооны хуралдаан түр завсарлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА